



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, 20.2.3 дахь заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2011 оны "Вакцины тухай" А/122 дугаар тушаал, 2012 оны "Дархлаажуулалтын тухай" А/217 дугаар тушаал, 2015 оны "Нөхөн дархлаажуулалтын тухай" А/261 дүгээр тушаал, 2016 оны "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/278 дугаар тушаал, 2024 оны "Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/359 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг нийслэлийн хэмжээнд 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 09 дүгээр сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Улирлын томуугийн эсрэг вакцины хуваарийг нэгдүгээр, вакцины зааврыг хоёрдугаар, дархлаажуулалтын хамралтын мэдээ авах маягыг гуравдугаар, зөвшөөрлийн хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархжаалуулалтыг үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж, мэдээ тайланг цаг тухайд нь гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэхийг Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс (З.Болормаа), заавал хийх товллын дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдүүдийг нөхөн дархлаажуулах, дархлаажуулалтын ач холбогдолын тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Эрүүл мэндийг дэмжих, нийтийн эрүүл мэндийн хэлтэс (Д.Цэнд-Аюуш)-т тус тус үүрэг болгосугай.

4. Байгууллагын ажилчдыг улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулахыг харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5. Дүүргийн болон Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт дараах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхийг даалгасугай:

5.1. Харьяа дүүргийн эрсдэлт бүлгийн хүн ам, жирэмсэн эмэгтэйчүүд, бүх хэлбэрийн сургуулийн өмнөх боловсрол, асрамжийн төвийн 6 сараас 5 хүртэлх насны хүүхдүүд, эрүүл мэндийн байгууллагын ажилчдыг хуваарийн дагуу улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах, мөн "Дархлаажуулалтын 10 хоногоор цэцэрлэгийн хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг хамтатган чанарын стандартын дагуу зохион байгуулах,

1550001360

5.2. Дархлаажуулалтын 10 хоногийн үед нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дархлаажуулалтын байнгын болон явуулын цэгийн урсгал зохион байгуулалт, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм мөрдөж ажиллах, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдлэг сэргээх сургалтыг зохион байгуулах,

5.3. “Улирлын томуугийн эсрэг вакцин” болон заавал хийх дархлаажуулалтын ач холбогдлын талаарх мэдээллийг эцэг, эх, цэцэрлэг, асрамжийн төвийн эмч, багш нарт хийж, зөвшөөрлийн хуудсыг хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулж, гарын үсэг авсан байх,

5.4. Заавал хийх төвлөлт дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдүүдийг нөхөн дархлаажуулалтад хамруулах,

5.5. Дархлаажуулалтын 10 хоногийн үеэр вакцины хүйтэн хэлхээ, аюулгүй дархлаажуулалтын холбогдох тушаал, зааврыг нягт баримталж, хяналт тавих, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалтыг эрчимжүүлэн, бүртгэгдсэн тохиолдлыг цаг хугацаанд нь мэдээлэх, тандан судлах, хариу арга хэмжээ авах,

5.6. Дархлаажуулалтын мэдээг дүүргийн Эрүүл мэндийн төвийн халдвар судлаач эмч нар өдөр бүр 17:00 цагт Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс [/ubhd.mad@gmail.com/](mailto:ubhd.mad@gmail.com)-т цахим хаягаар ирүүлэх,

5.7. Дархлаажуулалтын 10 хоногийн хугацаанд ажилласан эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний илүү цагийн хөлсийг холбогдох хууль, тогтоомж, журамд нийцүүлэн олгох, эсвэл биеэр нөхөн амруулах зэрэг арга хэмжээг авах.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-т даалгасугай.

ДАРГА  П.ЭРХЭМБУЛГАН

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 23 ны өдрийн
... тушаалын нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
УЛИРЛЫН ТОМУУГИЙН ЭСРЭГ ВАКЦИНЫ ХУВААРЬ

Д/д	Дүүрэг	Вакцинд хамруулах зорилтот бүлэг				Шаардлагатай вакцин, тариур	
		Эрүүл мэндийн байгууллагын ажилтан	Жирэмсэн эмэгтэйчүүд	6 сартайгаас 5 хүртэлх насны хүүхдүүд	Эрсдэлт бүлгийн хүн ам /65 болон түүнээс дээш насны хүмүүс/	Олгох хүн тун 4 цэнт	Тариур 0,5 мл
		50%	10%	50%	50%		
1	Багануур дүүргийн эрүүл мэндийн төв	300	28	2,594	318	3,240	3,240
2	Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв	30	5	442	53	530	530
3	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	540	200	24,121	2,569	27,430	27,430
4	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв	960	375	33,326	10,609	45,270	45,270
5	Налайх дүүргийн эрүүл мэндийн төв	320	40	3,748	422	4,530	4,530
6	Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв	920	345	26,145	10,540	37,950	37,950
7	Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв	530	225	12,842	1,753	15,350	15,350
8	Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв	860	240	25,710	2,150	28,960	28,960
9	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв	460	130	13,104	1,586	15,280	15,280
10	Нийслэлийн түргэн тусламжийн төв	360				360	360
11	Нийслэлийн шүд эрүү нүүрний төв	100				100	100
12	Нийслэлийн эрүүл мэндийн газар	60				60	60
13	Наркологийн эмнэлэг	50				50	50

14	Энэрэл эмнэлэг	70				70	70
15	Сэргээн засах клиникийн эмнэлэг	100				100	100
16	Сэргээн засах хүүхдийн бяцхан тэмүүлэл төв	100				100	100
17	Нийслэлийн Зооноз өвчин судлалын төв	50				50	50
18	"Амгалан" амаржих газар	200				200	200
19	"Өргөө" амаржих газар	400				400	400
20	"Хүрээ" амаржих газар	150				150	150
Нийт		6,560	1,588	142,032	30,000	180,180	180,180

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 28 дугаар сарын 28-ны өдрийн
А/426 тушаалын хоёрдугаар хавсралт



УЛИРЛЫН ТОМУУГИЙН ЭСРЭГ "GCFLU" ДӨРВӨН ЦЭНТ ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Улирлын томуугийн эсрэг "GCFLU" дөрвөн цэнт вакцин нь 2024/2025 оны томуугийн улиралд ДЭМБ-ын зөвлөмж болгосон томуугийн вирусийн эсрэгтөрөгчийг идэвхгүйжүүлж гаргаж авсан, ДЭМБ-ын чанар, аюулгүй байдлын урьдчилсан шалгуур хангасан вакцин юм. Вакцины найрлагад орсон томуугийн вирусийн дөрвөн дэд хэвшинжээр үүсгэгдсэн халдвараас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

Тодорхойлолт:

GCFLU дөрвөн цэнт вакцин нь эсрэгтөрөгч чанарыг нь хадгалахын тулд өндөгний үр хөврөлд тарьж өсгөвөрлөсөн, томуугийн вирусийг задалж, идэвхгүйжүүлэх аргаар гаргаж авсан өнгөгүй, бүдэг цайвар өнгө бүхий вакцин юм.

Найрлага:

0.5 мл-т агуулагдах найрлага:

Идэвхтэй хэсэг: Томуугийн вирусийн цэвэршүүлж, идэвхгүйжүүлсэн антиген.....120µg

А хүрээний Victoria/4897/2022 IVR –238 (H1N1)	30µg
А хүрээний Darwin/9/2021 SAN-010 (H3N2)	30µg
В хүрээний /Austria/1359417/2021 BVR-26.....	30µg
В хүрээний /Phuket/3073/2013.....	30µg

Нэмэлтээр натри, калийн хлорид, гидрофосфат натри, калийн дигидроген фосфат, тиомерсал, тарилгын ус агуулна.

Савлагаа:

Нэг хүн тун нь 0,5 мл, нэг флаконд 10 хүн тунгаар савлагдсан. Өнгөгүй шингэн хөвмөл.

Заалт:

Томуугийн А болон В хүрээний вирусээр үүсгэгдсэн томуугийн халдвараас урьдчилан сэргийлж 6 сар ба түүнээс дээш насны хүмүүст хэрэглэнэ.

Тун ба тарих арга:

Вакциныг гарын бугалганы (делтойд) булчинд тарьж хэрэглэнэ.

- 6 сар ба түүнээс дээш насны хүмүүст: 0.5 мл-ээр нэг удаа тарина.

Эсрэг заалт:

Вакцинжуулахын өмнө тухайн хүнээс асуумж авч, бодит үзлэг хийнэ. Үзлэгээр дараах эмгэгийн аль нэг нь илэрсэн тохиолдолд вакцинжуулахыг зөвлөхгүй.

- Цочмог халдвар, архаг өвчний сэдэрлийн үе;
- Вакцины найрлагад орсон бодист анафилаксийн урвал илэрч байсан өгүүлэмжтэй;
- Өндөг, тахианы мах, тахианы гаралтай бүтээгдэхүүнд хэт мэдрэг хариу урвал өгч байсан;
- Сүүлийн нэг жилийн хугацаанд таталт; саажилтын хамшинж илэрсэн;
- Мэдрэлийн үрэвслийн хамшинжийн үе;
- Харшил, багтраа өвчтэй хүн;
- Дархлал дутмагшилтай хүн;

- Дааврын эмчилгээ болон дархлаа дарангуйлах, дархлаа сэргээх эмчилгээ хийлгэж байгаа хүн;
- Өмнө нь томуугийн вакцин хийлгэсэнээс хойш 6 долоо хоногийн дотор Гиллен-Барын хамшинж илэрч байсан эсвэл мэдрэлийн эмгэгтэй хүн;
- Хавдрын эмчилгээний цитостатик эм хэрэглэж байгаа бол;

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл:

- Халуурах, толгой өвдөх, чичрэх, ядрах, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих зэрэг ерөнхий, тариулсан газарт улайх, хөндүүрлэх, хавдах зэрэг хэсэг газрын урвалын шинж илэрч болох бөгөөд 2-3 өдрийн дараа хэвийн байдалд ордог.
- Ховор тохиолдолд: Толгой эргэх, цочмог ханиах, архаг ринит, хоолой өвдөх, залгиурын үрэвсэл, хамрын салст бүрхэвчийн үрэвсэл илэрч болно.
- Маш цөөн тохиолдолд: бөөлжих, суулгах, дотор муухайрах, чонон хөрвөс гарах, анафилаксийн шок, энцефаломиелит, татах, мэдрэлийн өөрчлөлтүүд 2 долоо хоногийн дотор илэрч болно. Хэрэв дээрх шинж тэмдэг илэрвэл эмч, эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлж, эмчийн зааврын дагуу эмчилгээг хийх хэрэгтэй.

Анхааруулга:

- Вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгт хамруулна
- Томуугийн вакциныг товлолын бусад вакцинтай нэг өдөр хийж болох бөгөөд тарих талбай өөр байна.
- Бусад вакцинтай 28 хоногийн завсартайгаар хийнэ.
- Тарилгын стандартыг баримтлан ажиллана.
- Задалсан вакциныг дараах нөхцөлийг хангасан тохиолдолд 7 хоногийн дотор хэрэглэж болох бөгөөд задалсан огноо, цаг, минутыг заавал тэмдэглэнэ.
 - Вакциныг +2- +8 хэмд хадгалсан
 - Вакциныг шошгоны бичиг арилаагүй
 - Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажилласан
- Тарилга хийсэн хэсэг газрыг бохирдуулахгүй, цэвэр байлгах, ус хүргэхгүй, цохихгүй, маажихгүй байх талаар зөвлөнө. Мөн дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илэрсэн тохиолдолд эмчид яаралтай хандахыг вакцин хийлгэж байгаа хүнд зөвлөнө.

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд:

Вакцин хийхийн өмнө жирэмсэн болон хөхүүл эмэгтэйг эмчийн үзлэгт хамруулна. Жирэмсний 14-өөс 36 долоо хоногтой жирэмсэн эмэгтэйд томуугийн вакцин хийж болно.

Хадгалалт, тээвэрлэлт, савлагаа:

- Вакциныг +2- +8 хэмд гэрлээс хамгаалж, хадгалан тээвэрлэнэ.
- Халууны нөлөөнд өртсөн эсэхийг вакцин шошгоны монитормыг ашиглан хянана.
- Хөлдөөж болохгүй.
- Нэг хүн тун нь 0,5 мл, нэг флаконд 10 хүн тунгаар буюу 5 мл-ээр савлагдсан.

Хүчинтэй хугацаа: 2025 оны 06 дугаар сарын 23

Үйлдвэрлэгч: Грийн кросс корпораци, БНСУ

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн
тушаалын гуравдугаар хавсралт



УЛИРЛЫН ТОМУУГИЙН ВАКЦИНЖУУЛАЛТЫН ХАМРАЛТЫН МЭДЭЭ

МАЯГТ 1. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ [6 сартайгаас 5 настай хүүхэд]

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр					ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь	6-12 сар	2 нас	3 нас	4 нас	5 нас	
1										
2										

Хамралтын мэдээг өдөр бүр 17:00 цагт Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс [/ubhd.mad@gmail.com/](mailto:ubhd.mad@gmail.com)-т цахим хаягаар ирүүлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

МАЯГТ 2. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ [Жирэмсэн эмэгтэй]

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр			ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь	16-24	25-34	35-49	
1								
2								

Хамралтын мэдээг өдөр бүр 17:00 цагт Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс [/ubhd.mad@gmail.com/](mailto:ubhd.mad@gmail.com)-т цахим хаягаар ирүүлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

МАЯГТ 3. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ [65 болон түүнээс дээш настай хүмүүс]

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр			ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь	65-75	75-85	85+	
1								
2								

Хамралтын мэдээг өдөр бүр 17:00 цагт Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс [/ubhd.mad@gmail.com/](mailto:ubhd.mad@gmail.com)-т цахим хаягаар ирүүлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

МАЯГТ 4. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ [Архаг, хууч]

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр				ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь	16-24	25-49	50-64	65-с дээш	
1									
2									

Хамралтын мэдээг өдөр бүр 17:00 цагт Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс /ubhd.mad@gmail.com/-т цахим хаягаар ирүүлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

МАЯГТ 5. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ [Эрүүл мэндийн байгууллага]

№	Байгууллагын нэр	Нийт			Мэргэжилээр			Насны бүлгээр				ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь	ЭМ	Сувилагч	Бусад	16-24	25-49	50-64	≥ 65	
1												
2												

Хамралтын мэдээг өдөр бүр 17:00 цагт Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс /ubhd.mad@gmail.com/-т цахим хаягаар ирүүлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

МАЯГТ 6. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ [Бусад албан байгууллага]

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр				ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан хүний тоо	Хамралтын хувь	16-24	25-49	50-64	≥ 65	
1									
2									

Хамралтын мэдээг өдөр бүр 17:00 цагт Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс /ubhd.mad@gmail.com/-т цахим хаягаар ирүүлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
.../.../... тушаалын дөрөвдүгээр хавсралт



УЛИРЛЫН ТОМУУГИЙН ВАКЦИН ХИЙХЭД ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ,
АСРАН ХАМГААЛАГЧААС АВАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

Миний хүү/охин овогтой нь
..... настай. дүүргийн хорооны сургууль, цэцэрлэгт
суралцдаг.

Эцэг эх асран хамгаалагч Би хүүхдэдээ улирлын томуугийн вакцин хийлгэхийг
зөвшөөрч байна.

Улирлын томуугийн эсрэг вакцины зааврыг уншиж, танилцсан болно.

Гарын үсэг: эцэг/ эх / асран хамгаалагч

Огноо: 2024 оны дугаар сарын өдөр

Тайлбар: Хүүхдүүдийг улирлын томуугийн эсрэг вакцинд хамруулахаас өмнө энэхүү зөвшөөрлийн хуудсыг ангийн багш, өрхийн эмч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид заавал танилцуулж, гарын үсэг авсан байна. Сүүлийн нэг сарын хугацаанд товлолын болон сайн дураар томуугийн вакцинд хамрагдаагүй байх.